

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар: 03

Улаанбаатар хот

Бодлогын баримт бичиг
батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан даатгалын багц дүрмийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 3.4.2.6.ж, 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”, 558 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ын 1.2, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.5-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн “Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг”-ийг хавсралтаар баталсугай.


2. “Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг”-ийн хэрэгжилтийг хангаж, холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн хороо (Я.Батханд)-нд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Үндэсний давхар даатгал” ХК (цаашид “компани” гэх)-ийн эрсдэлийн удирдлагын талаар баримтлах бодлогыг энэ баримт бичгээр тодорхойлно.

1.2. Энэ баримт бичиг нь компанийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Хоёр. Эрсдэлийн удирдлагын бодлого

2.1. Компани учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, түүнийг үнэлж, бууруулах арга замыг тодорхойлох ба оновчтой удирдах зорилгоор эрсдэлийн удирдлагын журам, аргачлалыг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөр батлуулна.

2.2. Эрсдэлийн удирдлагын журам, аргачлалд дараах зүйлийг тусгасан байна:

2.2.1. Эдийн засаг, зах зээлийн төсөөлөл, тэдгээрээс компанийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл;

2.2.2. Зорилтот зах зээл, бизнесийн зорилгодоо хүрэх нөөц бололцоо /хөрөнгө санхүү, боловсон хүчин гэх мэт/ зорилгоо биелүүлэхэд учирч болзошгүй, холбогдох эрсдэлүүдийг таних, хэмжих, хянах талаар;

2.2.3. Эрхэлж буй даатгалын төрөл, хэлбэр, төвлөрлийн байдлын талаар;

2.2.4. Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх, удирдах, бууруулах арга хэмжээний талаар.

2.3. Компани энэ баримт бичигт заасантай нийцүүлэн ТУЗ-өөс баталсан эрсдэлийн удирдлагын журам, аргачлалын хэрэгжилтийг ханган ажиллаж, тэдгээр журам, аргачлалд заасан эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлнэ.

2.4. Энэ баримт бичигт хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.4.1. “Эрсдэлийн удирдлага” гэж эрсдэлүүдийг тодорхойлж, үр дүнтэй удирдах, хянах зохицуулалт бүхий үйл ажиллагааг;

2.4.2. “Эрсдэлийн удирдлагын тогтолцоо” гэж эрсдэлийн удирдлагын бодлого, стратеги болон тэдгээрт тусгагдсан эрх үүрэг, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө, нөөц бололцоо, хариуцлагын бүрдлийг;

2.4.3. “Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа” гэж эрсдэлийг тодорхойлох, шинжлэх, дүгнэх, арга хэмжээ авах, мониторинг хийх ба хянах үйл ажиллагааг дэс дараалалтай хэрэгжүүлэх дадлыг;

2.4.4. “Эрсдэл хариуцагч” гэж эрсдэлийг удирдах, эрх мэдэл, үүрэг хариуцлага бүхий ажилтныг;

2.4.5. “Эрсдэлийн хороо” гэж гүйцэтгэх удирдлагын тушаалаар байгуулагдсан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж, шийдвэр гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгийг.

2.5. Эрсдэлийн удирдлагын бодлогын үзэл баримтлал:

2.5.1. Компанийн урт хугацааны тогтвортой үйл ажиллагааны баталгааг эрсдэлийн удирдлага хангана.

2.5.2. Эрсдэлийн удирдлагыг компанийн бүхий л үйл ажиллагаанд хамааруулна.

2.5.3. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нь компанийн нийт ажилтан бүрийн үүрэг, хариуцлага байна.

2.6. Эрсдэлийн удирдлагын бодлогод баримтлах зарчим:

2.6.1. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь хараат бус, мэргэшсэн, ил тод, хариуцлагатай, хяналттай байх;

2.6.2. Эрсдэлийн тайланг батлагдсан загварын дагуу тогтмол давтамжтай удирдлагад тайлагнах;

2.6.3. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг журмаар зохицуулах;

2.6.4. Эрсдэл учруулж болзошгүй шийдвэр гаргах эрх мэдлийг нэг албан тушаалтанд төвлөрүүлэхээс зайлсхийх.

2.7. Эрсдэлийн удирдлагын бодлогын стратеги:

2.7.1. Эрсдэлийн удирдлагын тогтолцоог үр дүнтэй болгох;

2.7.2. Эрсдэлийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох;

2.7.3. Эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх;

2.7.4. Эрсдэлийг эрт илрүүлдэг байх тогтолцоог нэвтрүүлэх;

2.7.5. Зорилтот өгөөжийн түвшинд хүлээж болзошгүй алдагдлыг хамгийн бага байлгах;

2.7.6. Үйл ажиллагааны эрсдэлийг боломжит хамгийн бага түвшинд байлгах;

2.7.7. Ашигт ажиллагаа, үр ашигт байдал болон төлбөрийн чадварын боломжит түвшинг тодорхойлох.

2.8. Эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа дараах 5 үе шаттай байна:

2.8.1. Эрсдэлийг ангилах: Эрсдэлийг гадаад эрсдэл, стратегийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, санхүүгийн эрсдэл, комплаенсын эрсдэл гэж ангилна.

2.8.2. Эрсдэлийг шинжлэх: Эрсдэлийг шинжлэхэд эрсдэлийн ангилал болон тодорхойлолт, ABC арга, дулааны матрицын болон бусад аргуудыг ашиглана.

2.8.3. Эрсдэлийн түвшинг тогтоох:

Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
1	2	3	4	5

2.8.4. Эрсдэлд хариу арга хэмжээ авах:

Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
Хүлээн зөвшөөрнө	Сайжруулах	Төсвөөр шийднэ, Хуваалцах	Бууруулна	Зайлхийнэ, Шилжүүлнэ, Хязгаарлана

2.8.5. Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих: Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд компанийн Эрсдэлийн хороо, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж хяналт тавин ажиллана.

2.9. Эрсдэлийн удирдлагын бодлогын засаглал нь хамгаалалтын дараах гурван шугамтай байна:

2.9.1. Нэгдүгээр шугам: Компанийн газар, нэгжийн бүх ажилтан эрсдэлийг үнэлэх, бууруулахад чиглэн ажиллана.

2.9.2. Хоёрдугаар шугам: Компанийн Эрсдэлийн хороо эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй байдлыг үнэлэн ажиллана.

2.9.3. Гуравдугаар шугам: Дотоод аудит эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хянан шалгаж, хараат бус дүгнэлт гарган ажиллана.

2.10. Эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэгчдийн чиг үүрэг:

2.10.1. ТУЗ:

2.10.1.1. Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг, журам, аргачлалыг батлах;

2.10.1.2. Эрсдэлийн удирдлагын үр ашигт байдалд дүгнэлт хийх.

2.10.2. Эрсдэлийн хороо:

2.10.2.1. Компанийн үйл ажиллагааг хэвийн, тогтвортой явуулахад саад учруулж болзошгүй эрсдэлд хариу арга хэмжээ авах;

2.10.2.2. Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хангах;

2.10.2.3. Эрсдэлийн удирдлагын тогтоосон хязгаарлалтуудыг мөрдөх;

2.10.2.4. Эрсдэлийн тайлан, холбогдох санал, дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;

2.10.2.5. Эрсдэлийг бууруулахад шаардлагатай санхүү болон төсвийн асуудлыг шийдвэрлэх.

2.10.3. Эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж:

2.10.3.1. Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хязгаарын хүрээнд холбогдох шаардлагуудыг мөрдүүлэх;

2.10.3.2. Компанийн үйл ажиллагааны эрсдэлийн түвшинг тодорхойлох;

2.10.3.3. Эрсдэлийн бодлогын зорилтыг хангах;

2.10.3.4. Эрсдэлийг удирдах, бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

2.10.3.5. Эрсдэлийн тайланг боловсруулах;

2.10.3.6. Компанид эрсдэлийн соёлыг түгээх.

2.10.4. Эрсдэлийн удирдлага хариуцсан нэгжээс бусад компанийн газар нэгж:

2.10.4.1. Эрсдэлийн стратеги зорилтуудыг хангах;

2.10.4.2. Компанийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлж болзошгүй, эсвэл өсөн нэмэгдэж буй эрсдэлүүдийг хариуцах;

2.10.4.3. Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрсдэлийн шинжилгээ хийх;

2.10.4.4. Эрсдэлийн тайлагнал, мэдээллээр хангах.

2.10.5. Дотоод аудит:

2.10.5.1. Эрсдэлийн хяналтын систем, эрсдэлийн тайлагнал, эрсдэлийн чиглэлээр гаргасан тогтоол, шийдвэрийн талаар дүгнэлт өгөх;

2.10.5.2. Эрсдэлийн удирдлагын бодлого, журам, заавар болон арга зүйн зөрчил, дутагдлыг арилгуулах чиглэлээр зөвлөмж, үнэлгээ өгөх;

2.10.5.3. Эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэхэд хяналт тавих.

Гурав. Бусад зүйл

3.1. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо энэ баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавина.

3.2. Энэ баримт бичгийг холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг компани хариуцна. Энэ баримт бичгийг шинээр баталсан болон нэмэлт, өөрчлөлт оруулснаас хойш 14 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

3.3. Компани энэ баримт бичигт тусгагдаагүй эрсдэлийн удирдлагатай холбоотой аливаа асуудлыг Даатгалын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”, “Эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тооцсон төлбөрийн чадварын зохистой харьцааны журам” болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ.

3.4. Компанийн эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж, эрсдэл хариуцагч энэ баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.5. Энэ баримт бичгийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага ногдуулна.

---oOo---

